

Иосеф Смитийн Орчуулга

Их Эзэн Библийн Иосеф Смитийн Орчуулгаар дамжуулан нэмэлт сургаалуудыг сэргээсэн.

Та судраасаа Мосегийн номыг олж чадах уу? Их Эзэн Библийн Иосеф Смитийн Орчуулгаар дамжуулан Мосегийн сургаал, үзэгдэл, бусад нэмэлт мэдлэгийг сэргээсэн юм. Эдгээр нь Агуу Үнэт Сувд дахь Мосегийн номд багтсан байдаг.

Моисе 1:3–4, 6, 8, 39-ийг уншина уу. Моисе үзэгдлийнхээ үеэр өөрийнхөө болон Их Эзэний тухай юу мэдэж авсныг олж мэд. (Та мөн Мосегийн ном дахь хамгийн дуртай шүлгүүдээ хайж олж болно.)

- Биднийг Аврагчийг дагахыг хичээх үед эдгээр шүлэг дэх сургаалууд бидэнд хэрхэн тусалж болох вэ?
- Эдгээр шүлэгт Их Эзэний илчилсэн зүйлд хэн нэгэн яагаад талархдаг байж болох вэ?

Их Эзэн Библийн Иосеф Смитийн Орчуулгаар дамжуулан “энгийн бөгөөд эрхэм үнэнүүдийг” сэргээсэн.

Та Библид зарим чухал үнэн алга болсон эсвэл тодорхойгүй байж болох талаар сонсож байсан уу? Библи нь итгэж болох, сүнслэгээр өдөөгдсөн ном юм. Гэсэн хэдий ч Нифай “тодорхой болон эрхэм үнэт зүйл” нь алга болсон эсвэл тодорхойгүй байсныг заасан (1 Нифай 13:28–29). Тухайлбал, Библи дээр Шинэ Гэрээнээс өмнө баптисмыг шууд дурддаггүй бөгөөд Ноагийн библийн түүх Их Эзэн хүмүүст сэрэмжлүүлж мөн үерээс өмнө наманчлах боломжийг тэдэнд өгсөн гэдгийг тайлбарладаггүй.

Их Эзэн Иосеф Смитийн Орчуулга дахь эрхэм үнэнүүдийг хэрхэн сэргээснийг харахын тулд Моисе 6:64–66 ба 8:16–17, 20-ийг уншина уу.

- Баптисм нь Адамын өдрүүдээс хойш өгөгдсөн зарлиг гэдгийг мэдэх нь өнөөдөр бидэнд хэрхэн тусалж болох вэ?
- Их Эзэн үргэлж биднийг наманчлахад урьж, уучлахад бэлэн байдгийг мэдэх нь бидэнд хэрхэн тусалж болох вэ?
- Эдгээр үнэн Есүс Христээр дамжуулан авралд хүргэхэд бидэнд хэрхэн тусалдаг вэ?

Иосеф Смитийн Орчуулга дахь Их Эзэний илчлэлт Сургаал ба Гэрээн дэх нэмэлт илчлэлтүүд рүү хөтөлсөн.

Судраас судлах нь нэмэлт илчлэлт хүлээн авахад танд тусалж байсан уу? Энэ нь Иосефт тусалсан. Тэрээр сүнслэгээр орчуулж байхдаа Енохын тухай болон түүний хүмүүсийн Сионыг байгуулсан (Моисе 7:18–21-ийг үзнэ үү) тухай олж мэдсэн ба төд удалгүй Их Эзэн гэгээнтнүүдэд Сионы хүмүүс (Сургаал ба Гэрээ 38, 42, 45-ыг үзнэ үү) болоход нь туслах зааварчилгааг Иосефт илчилсэн билээ.

Үүний өөр нэгэн жишээ нь Иосеф Смит, Сидней Ригдон хоёр Иохан 5:29-ийг орчуулж байх үед тохиолдсон юм. Тэдэнд тэнгэр болон тамын тухай асуултууд байсан нь одоогийн Сургаал ба Гэрээ 76-д цэдэглэгдсэн гайхамшигт үзэгдлийг хүлээн авахад хүргэжээ. Энэхүү үзэгдэл энэ амьдралын дараа хүмүүсийн өвлөн авах боломжтой алдар суугийн гурван зэрэглэлийн тухай үнэнийг багтаасан байдаг.

Сургаал ба Гэрээ 76:22–24, 50–53 ба 58–62-ыг уншаад, Есүс Христийн тухай мөн Түүнтэй болон Тэнгэрлэг Эцэгтэй хамт амьдрахаар хэрхэн эргэн очих талаар юу сурснаа тэмдэглэ.

- Та ямар үг, хэллэгийг тэмдэглэсэн бэ? Яагаад?
- Яагаад хэн нэгэн эдгээр үнэнийг мэдэж байгаадаа талархаж болох вэ?

Их Эзэн Иосеф Смитийн Орчуулгаар дамжуулан Библийн шүлгүүдийн талаар сургаалын тодорхой байдал хийгээд нэмэлт ойлголтыг өгсөн.

Агуу Үнэт Сувдаас өөр Библийн Иосеф Смитийн Орчуулгыг хаанаас олохоо та мэдэх үү? Дийлэнх нь судрын арын хэсэгт байрлах Библийн Иосеф Смитийн Орчуулгын түүвэрт эсвэл Gospel Library аппликэйшны Судлах

тусламж хэсэгт байгаа Иосеф Смитийн Орчуулгын хавсралтад байдаг. Доор байгаа жишээ, тайлбарыг харж; эдгээр эх сурвалжийг хэрхэн ашиглах талаар олж мэд.

БИБЛИЙН ИОСЕФ СМТИЙН ОРЧУУЛГААС АВСАН ТҮҮВРҮҮД

Библийн Хаан Жеймсийн хувилбараас Иосеф Смитийн орчуулсан (ИСО) хэсгүүдийн түүврийг дор харуулав. Анхны үгс бичигдсэнээс хойш алга болсон буюу өөрчлөгдсөн үнэнүүдийг Библийн эх сэдэвт сэргээхэд Их Эзэн, Бошиглогч Иосеф Смитийг урамшуулжээ. Эдгээр сэргээгдсэн үнэнүүд сургаалыг тодосгож, судруудыг ойлгох явдлыг сайжруулсан байна. Удирдамжид сонгож авсан хэсгүүд нь ямар хэлэнд орчуулагдсанаас үл хамааран судруудын талаарх та бүхний ойлголтыг сайжруулахад туслах болно.

Анхны зохиогчдын нэгэнт цэдэглэсэн үнэнүүдийг Их Эзэн Иосеф Смитэд илчилсэн учир, Иосеф Смитийн орчуулга нь дэлхий дэх Библийн өөр ямар ч орчуулгатай адилгүй юм. Энэ утгаараа, орчуулга гэдэг үг ердийнхөөсөө илүү өргөн хийгээд өөр байдлаар хэрэглэгддэг, учир нь Иосеф Смитийн орчуулга бол ердөө л нэг хэлнээс нөгөөд хөрвүүлсэн орчуулга гэхээс илүү илчлэлт байлаа. ИСО-ын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Удирдамж дахь цагаан толгойн дэс дарааллаарх сэдвийн жагсаалт дахь Иосеф Смитийн Орчуулгаас үз. ИСО-аас авсан түүврийн загварыг дор харуулав:

Түүний орчуулга Библийн эх сэдэвт үгсийг сэргээсэн учир шүлгүүдийн дугаар нь таны ашиглаж буй хэвлэлийнхээс өөр байж болно.

ИСО, Матай 4:1, 5–6, 8–9 (Матай 4:1, 5–6, 8–9-тэй харьцуул; мөн үүнтэй адил өөрчлөлтүүд Лук 4:2; 5–11-д хийгджээ). Иосеф Смитийн орчуулгатай таны харьцуулах ёстой Библийн ишлэл хаалтан дотор байгаа болно.

(Есүс Сатанаар биш, Сүнсээр хөтлөгдөө.)

1 Тийнхүү Есүс Бурхантай хамт байхаар цол уруу Сүнсээр хөтлөгдөв.

5 Тэгээд Есүс ариун хотод аваачигдан, мөн Сүнс түүнийг ариун сүмийн орой дээр тавив.

6 Тэгтэл чөтгөр түүн дээр хүрч ирэн хэлсэн нь, Хэрэв чи Бурханы хүү юм бол, өөрийгөө доош хая: учир нь энэ нь бичигдсэн билээ, Тэрээр чиний талаар тэнгэр элчүүддээ санаа тавихыг үүрэг өгөх болно; мөн ямар ч үед чи хөлөөрөө чулуу өшиглөхгүйн тулд тэд чамайг гар дээрээ авч явах болно.

8 Мөн дахин, Есүс Сүнсэн дотор байв, мөн энэ нь түүнийг үлэмж өндөр ууланд аваачиж, тэгээд дэлхийн бүх хаант улсууд хийгээд тэдгээрийн алдар сууг түүнд харуулав.

9 Мөн чөтгөр түүн дээр дахин хүрч ирэн, эдгээр бүх зүйл байх болно хэмээн хэлэв.

Тод үсгээрх ишлэл нь Хаан Жеймсийн Библиас Иосеф Смитийн хийсэн орчуулгын хэсэг юм.

Энэхүү нотолгоо нь Иосеф Смит өөрийнхөө орчуулгаар ямар сургаалыг тодруулсныг тайлбарладаг.

Энэ бол Иосеф Смитийн орчуулсан эх сэдэв юм.

Зарим хэлэнд, Иосеф Смитийн Орчуулгын хэсгүүдийг Библийн Хожмын үеийн гэгээнтнүүдийн хувилбар дээрх зүүлт тайлбар хэсгээс эсвэл дижитал төхөөрөмжүүд дээрээс “Холбоотой агуулга” гэсэн хэсгээс олж болно.

Библийн дараах хэсгүүдийг уншаад, Иосеф Смитийн Орчуулгыг ашиглан сүнслэгээр өдөөгдөн гарсан өөрчлөлтүүдийг олж тогтоо.

Иохан 1:16–18 (Иосеф Смитийн Орчуулга, Иохан 1:16–19)

Иохан 4:24 (Иосеф Смитийн Орчуулга, Иохан 4:26)

Иохан 6:44

- Эдгээр сүнсний өдөөлтөөр гарч ирсэн өөрчлөлт Есүс Христийн тухай танд юу зааж байна вэ?
- Эдгээр зүйлийг илүү сайн ойлгох нь яагаад адислал байдаг вэ?